

**“ДИСПЕТЧЕРИЙН ҮНДСЭНИЙ ТӨВ” ХХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС**

2017 оны 03 дугаар сарын 09 өдөр

№. 03

Улаанбаатар хот

“Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн хурлын тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Арилжааны зохицуулалтын 2017 оны 1 дүгээр улирлын тайлан

ТЭМДЭГЛЭСЭН НЬ:

....НХА-ийн 2017 оны 1 дүгээр улирлын дүнгээс харахад 2-р сард 1,055.60 сая төгрөгийн алдагдалтай ажилласан.

Шалтгаан нь: Түгээх болон үйлдвэрлэгч компаниудын энерги төлөвлөгөөнөөс давсан, Салхит цахилгаан станцын дутуу нийлүүлсэн цахилгаан эрчим хүчний төлбөр, Нарны станцын илүү үйлдвэрлэл, валютын ханшийн зөрүү зэргээс алдагдалтай ажилласан байна.

Диспетчерийн зохицуулалт нь хангалтгүй байна, зохицуулалтын үед Ухаа худаг, Салхит СЦС-ын төлөвлөгөөний гүйцэтгэл 85-89%, нарны станцын төлөвлөгөөний гүйцэтгэл 195.36%-иар биелүүлж, энэ нь 908,0 сая төгрөгийн алдагдал үүсэх боломжийг бүрдүүлсэн байгаа нь зохицуулалт буруу болсон байна... гэж тэмдэглэжээ.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Компанийн гүйцэтгэх захирал Д.Балдоржид үүрэг өгөх нь:

Үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн горим төлөвлөлтөнд дараахь асуудлуудыг хатуу мөрдлөг болгон ажиллах. Үүнд:

1. Жилийн батлагдсан төлөвлөгөөг мөрдөх,
2. Өдөр тутмын горим төлөвлөлтийг үр ашигтай төлөвлөж, зохицуулах төлөвлөх,
3. Нар болон салхины эх үүсвэрүүдийн горимыг батлагдсан төлөвлөсөнөөс хэтрүүлэн ажиллуулж байгаа нь НХА-ийн санхүүгийн эх үүсвэр дутагдах, цаашид алдагдалд ороход нөлөөлж байгааг анхаарч засаж, залруулан ажиллах,
4. Зохицуулалтын хяналт дутмаг байгаад техникийн удирдлага анхаарч ажиллахыг үүрэг болгох...гэжээ”.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА **Д.ИМЭДДОРЖ**

